

2022 ОНД ШИНЭЭР ТОГТООГДСОН СУМДЫН ТЭТГЭВРИЙН ХУВИЙН ХЭРГИЙГ ШАЛГАСАН ДОТООДЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

2024.01.29

№01

Мөрөн

Хэлтсийн даргын баталсан удирдамж, 2023 оны дотоодын хяналт, шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хууль, холбогдох бусад журам, зааврын хэрэгжилт, тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт бичгийн үндэслэлийг Хяналт шалгалт, дотоод аудитийн тасгийн дарга П.Майнбаяр нь 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Шалгалтанд нийт 23 сумын 1480 тэтгэврийн хувийн хэрэг хамрагдсан байна. Үүнээс ӨН-1180, ТД-238, ТА-62

Нэг. Шинээр тогтоогдсон тэтгэврийн хувийн хэргийн талаар:

2022 ОНД ШИНЭЭР ТОГТООГДСОН ХУВИЙН ХЭРЭГ

Хүснэгт-1

№	Сум	Хариуцсан байцаагч	Нийт тоо	Үүнээс			Зөрчлийн дүн			
				ӨН	ТД	ТА	Х ү н и й то о	Илүү олгосон /мян.төг/	Х ү н и й то о	Дутуу олгосон
1	Алагэрдэнэ	Б.Отгонцэцэг	42	32	6	4				
2	Арбулаг	А.Сумьяа	43	32	8	3				
3	Баянзүрх	Ө.Баасанхүү	50	38	8	4				
4	Бүрэнтогтох	В.Оюунчимэг	34	24	7	3				
5	Галт	Д.Отгонжаргал	72	58	13	1				
6	Жаргалант	Г.Пүрэвхишиг	172	155	10	7				
7	Рэнчинлхүмбэ	Б.Очмаа	65	50	15					
8	Тосонцэнгэл	Д.Эрдэнэтуяа	83	83			4	61076.4		
9	Улаануул	С.Оюундалай	62	48	14					
10	Их-Уул	П.Мөнхтүвшин	61	54	3	4				
11	Цагаан-Үүр	Ц.Энхтүвшин	36	33	3					
12	Цагааннуур	Б.Нарантуяа	43	27	13	3				
13	Цэцэрлэг	Д.Өлзий-Очир	73	56	15	2				

1 4	Хатгал	Д.Нандинцэцэг	52	31	18	3				
1 5	Чандмань-Өндөр	Ч.Туваансүрэн	54	42	7	5				
1 6	Эрдэнэбулган	Д.Мянган	56	45	10	1				
	Дүн		998	808	150	40	4	61076.4		

ЦАХИМ ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ХАМРАГДСАН СУМДЫН ТЭТГЭВЭР

Хүснэгт-2

№	Сумын нэр	Байцаагчийн нэр	Нийт тоо	Үүнээс			Зөрчлийн тоо			
				ӨН	ТД	ТА	Хүний тоо	Илүү олголт	Хүний тоо	Дутуу олголт
1	Цагаан-Уул	Ц.Оюунлхагва	101	85	15	1				
2	Ханх	Д.Оюунчимэг	33	28	5					
3	Тосонцэнгэл	Н.Эрдэнэтуяа	65	48	11	6				
4	Төмөрбулаг	Б.Болорцэцэг	56	37	9	10				
5	Рашаант	Н.Өлзийжаргал	45	36	7	2				
6	Шинэ-Идэр	Б.Өлзий	38	29	8	1				
7	Түнэл	Д.Болорцоож	59	51	8					
8	Тариалан	Н.Энхзаяа	85	58	25	2				
	Дүн		482	372	88	22				

1.1. Тэтгэврийн баримт материалын бүрдүүлэлтийн талаар

Хэлтсийн даргын баталсан удирамжийн дагуу Алагэрдэнэ, Арбулаг, Баянзүрх, Бүрэнтогтох, Жаргалант, Галт, Рэнчинлхүмбэ, Тосонцэнгэл, Улаан-Уул, Их-Уул, Цагааннуур, Цагаан-Үүр, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Хатгал, Цагаан-Уул, Рашаант, Ханх, Төмөрбулаг, Шинэ-Идэр, Эрдэнэбулган сумдын 1480 тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлсэн анхан шатны баримтын үндэслэл, тэтгэвэр тогтоосон нөхцлийг шалгахад 242 тэтгэвэр авагчтай холбоотой тэтгэвэр тогтоосон баримт материал дутуу бүрдүүлсэн болон бусад зөрчлүүд илэрсэн. Хяналт шалгалтын явцад Арбулаг-12, Жаргалант-20, Бүрэнтогтох-6, Рэнчинлхүмбэ-12, Баянзүрх-23, Эрдэнэбулган-5, Улаан-Уул-14, Хатгал-8, Галт-16, Цагааннуур-10, Алагэрдэнэ-10, Цэцэрлэг-13, Чандмань-

Өндөр-8, Цагаан-Үүр-8, Тосонцэнгэл-8, Төмөрбулаг-4, Рашаант-8, Ханх-2, Цагаан-Уул-6, Шинэ-Идэр-5, Их-Уул-21, Түнэл-4, Тариалан-5, нийт 228 тэтгэврийн хувийн хэрэгт баримт материалыг нэмж бүрдүүлж зөрчлийг шийдвэрлэж ажилласан байна.

1.2. Малчны тэтгэврийн хувийн хэргийг шалгасан талаар:

Хэлтсийн даргын баталсан удирдамжийн хүрээнд 2021-2022 онд хяналт шалгалтад хамрагдсан Жаргалант, Тосонцэнгэл сумдын 185 малчны тэтгэврийг дахин шалгалаа. Тус шалгалтаар Тосонцэнгэл сумын 4 тэтгэвэр авагчтай холбоотой 61076,4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн тул тэтгэврийн олголтыг зогсоож, улсын байцаагчийн акт тогтоосон. Үүнд:

1. Доржийн Сүхбат /РК64092514/ нь Тосонцэнгэл суманд оршин суудаг. 2019 оны 09-р сарын 25-ны өдөр малчин нөхцөлөөр тэтгэвэр тогтоогдсон, тэтгэврийн хувийн хэргийн дугаар №325453, Зөрчлийн утга: НДСОТТТХ-ийн 4-р зүйлийн 4.7 дахь заалтыг зөрчиж 2019 оны 09-р сараас 2023 оны 05-р сарыг дуустал хугацаанд 17702000 төгрөгийн тэтгэвэр илүү авсан. Цэргийн алба хаасан хугацаагаа 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1578 дугаартай шүүхийн шийдвэрээр малчнаар ажиллаж байснаар тогтоолгосон. 2023 оны 05-р сарын 29-ны өдөр 17/35 дугаартай улсын байцаагчийн акт тогтоогдсон. Төлбөрийг гэрээ байгуулж хуваарийн дагуу төлөхөөр тохирсон. Нийт 4400000 төгрөгийн төлбөр барагдсан.

2. Буянбадрахын Ганчимэг /РК69071804/ нь Тосонцэнгэл суманд оршин суудаг. 2019 оны 11-р сарын 2-ны өдөр малчин нөхцөлөөр тэтгэвэр тогтоогдсон, тэтгэврийн хувийн хэргийн дугаар №325861, Зөрчлийн утга: НДСОТТТХ-ийн 4-р зүйлийн 4.7 дахь заалтыг зөрчиж 2019 оны 11-р сараас 2023 оны 05-р сарыг дуустал хугацаанд 17133666 төгрөгийн тэтгэвэр илүү авсан. Дунд сургуульд суралцсан хугацаагаа малчнаар ажиллаж байснаар хөдөлмөрийн дэвтэрт бичилт хийсэн. 2023 оны 06-р сарын 13-ны өдөр 17/44 дугаартай улсын байцаагчийн акт тогтоогдсон. Төлбөрийг гэрээ байгуулж хуваарийн дагуу төлөхөөр тохирсон. Нийт 2380000 төгрөгийн төлбөр барагдсан.

3. Ямбээгийн Бадарч /РК66021613/ нь Тосонцэнгэл суманд оршин суудаг. 2021 оны 02-р сарын 16-ны өдөр малчин нөхцөлөөр тэтгэвэр тогтоогдсон, тэтгэврийн хувийн хэргийн дугаар №2293364, Зөрчлийн утга: НДСОТТТХ-ийн 4-р зүйлийн 4.7 дахь заалтыг зөрчиж 2020 оны 02-р сараас 2023 оны 05-р сарыг дуустал хугацаанд 12012500 төгрөгийн тэтгэвэр илүү авсан. Тээврийн техник мэргэжлийн суралцаж

байсан хугацаагаа 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 155/ШШ2020/02102 дугаартай шүүхийн шийдвэрээр малчнаар ажиллаж байснаар тогтоолгосон. 2023 оны 06-р сарын 13-ны өдөр 17/43 дугаартай улсын байцаагчийн акт тогтоогдсон. Нийт 4000000 төгрөгийн төлбөр барагдсан.

4. Чүлтэмийн Хөвсгөл /PK70092027/ нь Тосонцэнгэл суманд оршин суудаг. 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр малчин нөхцөлөөр тэтгэвэр тогтоогдсон. Тэтгэврийн хувийн хэргийн дугаар №2262936 Зөрчлийн утга: НДСОТТХ-ийн 4-р зүйлийн 4.7 дахь заалтыг зөрчиж 2020 оны 09-р сарын 22-ны өдрөөс 2023 оны 07-р сарыг дуустал хугацаанд 14228333 төгрөгийн тэтгэвэр илүү авсан. Дунд сургуульд суралцсан хугацаагаа 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 155/ШШ2020/01092 дугаартай шүүхийн шийдвэрээр малчнаар ажиллаж байснаар тогтоолгосон. 2023 оны 06-р сарын 13-ны өдөр 17/42 дугаартай улсын байцаагчийн акт тогтоогдсон. Төлбөрийг гэрээ байгуулж хуваарийн дагуу төлөхөөр тохирсон. Нийт 2128333 төгрөгийн төлбөр барагдсан.

ТЭТГЭВЭР ТОГТООЛТ ОЛГОЛТОД ХИЙСЭН ТӨЛБӨР ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт-3

д/д	Овог нэр	Регистрийн дугаар	Сум	Акт тогтоогдсон дүн	Барагдсан дүн	Үлдэгдэл дүн
1	Д.Сүхбат	PK64092514	Тосонцэнгэл	17702000	4400000	13302000
2	Б.Ганчимэг	PK69071804	Тосонцэнгэл	17133666	2380000	14753666
3	Я.Бадарч	PK66021613	Тосонцэнгэл	12012500	4000000	8012500
4	Ч.Хөвсгөл	PK70092027	Тосонцэнгэл	14228333	2128333	12100000
	Дүн			61076499	12908333	48168166

2022 онд шинээр тогтоогдсон тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт материалын үндэслэлийг шалгахад дээрх 228 тэтгэвэр авагчтай холбоотой баримт материалын зөрчил илэрсэн, энэ нь тэтгэврийн хувийн хэрэгт үрчлэлтийн захирамж, лавлагаа, халамжийн тодорхойлолт, төрсний лавлагаа, гэрлэлтийн гэрчилгээ, ажилд орсон гарсан тушаал, багийн засаг даргын тодорхойлолт, нөхөн даатгалын баримт лавлагаа зэргийг дутуу бүрдүүлсэн зэрэг нийтлэг зөрчлүүд байна. Мөн нийгмийн даатгалын дэвтрийн ажилд орсон гарсан бичилт хийгдээгүй, хөдөлмөрийн хөлсөнд хүрэхгүй цалинг хоног тооцоогүй, тэтгэвэр тогтоох цалин хөдөлмөрийн хөлсний дээд

хэмжээгээр хязгаарлалт хийгдсэн, жил илүү, дутуу тооцсон зөрчлүүд ахин давтагдаж байна.

Хоёр. Шийдвэрлэсэн байдал

Хэлтсийн даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр баталсан удирдамжийн дагуу сумдын 2022 онд тогтоогдсон 1306, мөн Тосонцэнгэл, Жаргалант сумдын малчны тэтгэвэр 174, нийт 23 сумын 1480 тэтгэврийн хувийн хэргийг шалгахад 4 хүнтэй холбоотой 61076,4 мянган төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчил илрэв. Энэ нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4,7, Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчиж байна.

Хяналт шалгалтын хүрээнд 4 тэтгэвэр авагчтай холбоотой нийт 61076.4 мянган төгрөгийн тэтгэвэр илүү олгосон төлбөр зөрчилд зөрчилд улсын байцаагчийн нийт 4 акт тогтоож шийдвэрлэв. Актын барагдуулалт 21,1 хувьтай байна. Шалгалтын хугацаанд нийт 228 тэтгэвэр авагчийн хувийн хэрэгт нэмэлт баримт бүрдүүлэлт хийсэн. Хяналт шалгалтын танилцуулга нь Их-Уул, Улаан-Уул сумдын баримт бүрдүүлэлт, албан шаардлагын биелэлт хангаагүй зэрэг байдлаас хойшилсон болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Тэтгэврийн хувийн хэргийн баримт материалын бүрдэл хангах, зөрчлийг шийдвэрлэх үндэслэлээр Баянзүрх сумын нийгмийн даатгалын байцаагч Ө.Баасанхүүд 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр, хэлтсийн Үйлчилгээний тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхдэлгэр, хяналтын байцаагч Б.Номин, тэтгэврийн байцаагч Н.Хөвсгөлдалай нарт 2023 оны 07 дугаар 31-ний өдөр, Их-уул сумын байцаагч П.Мөнхтүвшинд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр улсын байцаагчийн албан шаардлага тус тус хүргүүлсэн. Харин албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд гаргаж ирүүлээгүй байна. Энэ байдалд холбогдох тасгийн дарга, байцаагч албан тушаалтнууд анхаарч, шуурхай ажиллаж сурах шаардлагатай.

Гурав. Нэгдсэн дүгнэлт

Хэлтсийн даргын баталсан удирдамж, дотоодын хяналт шалгалтын төвлөвлөгөөний дагуу 2022 онд 23 сумын шинээр тогтоогдсон тэтгэврийн хувийн хэргийг баримтаар болон цахимаар шалгах ажлыг хийж гүйцэтгэлээ. Хяналт

шалгалтаар хэлтэс, сумдын байцаагчид тэтгэвэр тогтоох баримт материалыг анхан шатанд үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлээгүй нийтлэг зөрчлүүд давтагдсан хэвээр байна. Хэлтсийн тэтгэвэр тогтоолтын болон хяналтын байцаагч, тасгийн дарга нар тэтгэвэр тогтоох, хянах ажилд онцгой анхаарч ажиллах шаардлагатай. Мөн хэлтсийн холбогдох албан тушаалтнууд албан бичгийн хариуг хугацаанд нь ирүүлэх, шаардлага биелүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг шийдвэрлэх, Иргэд даатгуулагчдын тэтгэвэр тогтоох баримт материалыг хууль журамд заасны дагуу үндэслэлтэй бүрдүүлж авахгүй байдлаас хамаарч үндэслэлгүй тэтгэвэр тогтоогдох, олгогдох эрсдэл үүсч болохыг хэлтэс сумдын нийт байцаагч нар анхаарах хэрэгтэй. Тус хэлтсийн тасаг нэгжүүд ажлын уялдаа холбоог байнга хангаж, мэдээлэл солилцож, эрсдэлтэй, зөрчилтэй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах нь чухал гэж дүгнэж байна. Зөрчил дутагдал давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийгмийн даатгалын хэлтсийн бүх тасаг нэгжүүд байцаагч нарт шалгалтын танилцуулгаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөө.

Дөрөв. Хяналт шалгалтын хүрээнд гаргасан зөвлөмж, анхаарах асуудлууд:

1. Иргэд, даатгуулагчдын шимтгэл төлж ажилласан жилийн баримт материалыг анхан шатанд үнэн зөв бүрдүүлж, үндэслэлийг хангаж тэтгэвэр тогтоох, хуулийн зүйл заалтыг зөв хэрэглэх

2. Иргэний ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулсан жилийг (1990-2000), мөн Иргэний ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн хугацааг (1995-2019) нөхөн даатгалын цахим баримттай тулгаж шалгах. Малчнаас өөр ажил хөдөлмөр эрхэлж байсан, сургуульд суралцсан, цэргийн алба хаасан хугацаа нь нөхөн даатгалын жилтэй давхцсан эсэхийг магадлах, холбогдох баримтуудыг бүрдүүлэх

3. Шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн шимтгэл төлж ажилласан жил, цалин хөлсний мэдээлэл нь мэдээллийн санд үнэн зөв орсон эсэхийг тулгаж баталгаажуулсаны дараа тэтгэвэр тогтоох

4. Малчин нөхцлөөр тэтгэвэр тогтоолгох иргэдийн мал тооллогын “А” данс хууль журамд заасны дагуу бүртгэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллах (Өрхийн төрөл, малчдын тоо, бүртгэл мэдээлэл, малын тоо, гарын үсэг, он сар, өдөр, тамга тэмдэг)

5. Үрчлэлт хийгдсэн бол үрчлэлтийн лавлагаа, захирамжийг тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлэх

6. Энгийн болон цэргийн жилийг хууль, журамд заасны дагуу шилжүүлэн тооцож тэтгэвэр тогтоох
7. 1995-2019 онд ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулж, ӨН,ХЧА, ТА-ны тэтгэвэр тогтоолгох бол холбогдох онуудын А данс хувийн хэрэгт бүрдүүлэх
8. Цэргийн алба хаагаагүй бол холбогдох баримтыг хувийн хэрэгт хавсаргах
9. Сургуульд суралцсан хугацааны тодорхойлолт, гэрчилгээ болон холбогдох бусад баримтыг хувийн хэрэгт бүрдүүлэх (Ажилласан жил тэтгэврийн даатгалыг шимтгэлийг нөхөн төлсөн болон тооцуулсан)
10. Иргэд даатгуулагчдад малчин нөхцөлөөр тэтгэвэр тогтоохдоо аймаг, сумын архивын лавлагааг тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлэх (Ажилд орсон гарсан тушаал болон цалин хөлсний лавлагаа) Хөдөө аж ахуйн нэгдэлд ажилласан хугацааг 15 наснаас тооцох
11. Аж ахуйн нэгж, байгууллагад орж гарсан хугацааны тушаал, лавлагааг бүрэн бүрдүүлэх, томилогдсон чөлөөлөгдсөн хугацаагаар шимтгэл төлсөн хугацааг тооцож тэтгэвэр тогтоох, хөдөлмөрийн хөлсөнд хүрэхгүй цалин хөлсийг хоног тооцож бодох
12. Даатгуулагчийн нийт шимтгэл төлж ажилласан жил, цалин хөлсний мэдээлэл нэгдсэн мэдээллийн санд үнэн зөв орсон эсэхийг тулган баталгаажуулах (Өндөр нас 10 жил, 20 жил, 21.9 жил, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 3 жил, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 5 жилээр тэтгэвэр тогтооход анхаарч ажиллах)
13. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулсан болон төлсөн хугацааны үндсэн баримтыг мэдээллийн сантай тулган баталгаажуулж байх
14. НД-ын дэвтрийн ажилд орсон гарсан бичилт, баталгаажуулалтыг бүрэн хангах (2021 он хүртэл)
15. Нийгмийн даатгалын сангаас шинээр тэтгэврийн эрх үүсэж байгаа иргэд даатгуулагчид халамжийн сангаас тэтгэвэр авч байсан эсэхийг магадлаж шийдвэрлэх
16. 2022 онд Хяналт шалгалт, дотоод аудитийн тасгаас гаргасан хяналт шалгалтын танилцуулга ,зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах
17. Хэлтсийн тэтгэвэр тогтоолтын болон хяналтын байцаагч, тасгийн дарга нар тэтгэвэр тогтоох, хянах ажилд хариуцлагатай хандах

18. Цэргийн алба хаасан болон суралцсан хугацаа шүүхийн шийдвэртэй давхцсан эсэхийг магадлаж байх. Цэргийн алба хаасан хугацааны баримтыг бүрдүүлэх, алба хаагаагүй тохиолдолд нотлох баримтыг хавсаргах

19. 1995-2019 онд нөхөн даатгалд хамрагдсан хугацаанд Зөвлөлийн тогтоол гарсан бол зөвлөлийн баримттай тулгах (Зөвлөлийн тогтоол, хурлын тэмдэглэл, бусад нотлох баримт бүрэн байгаа эсэх)

20. Сайн дурын даатгал хийсэн онуудыг нэгдсэн мэдээллийн сантай тулган баталгаажуулж, тэтгэвэр тогтоох

21. Малчин нөхцлөөр тэтгэвэрт гарсан эмэгтэй даатгуулагчийн гэр бүлийн батлах хувийн хэрэгт хавсаргах

22. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулсан болон төлсөн хугацаа нэгдсэн мэдээллийн сантай тохирч байх

23. Хөдөө аж ахуйн нэгдэлд ажилласан хугацааг 15 наснаас тооцох

24. Хэлтэс сумдын нийт байцаагчид баримт материал шинжлэх, , ажлын арга зүйд суралцах, ур чадвараа дээшлүүлэх,

25. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон холбогдох журам, заавар, зөвлөмжийг мөрдөж ажиллах